

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### САЙНШАНД СУМЫН 150 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

Сайншанд сум

2024.06.17

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **13 000 000 /Арван гурван сая /** төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

3. Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

#### 1. Барилга их засварын ажил

Барилгын хүлээн авах хэсгийг сунган үүдний хэсгийн ханыг нурааж нэмэлт орон зай гарган шилэн хана хийх, шилэн гонх шинээр хийх. 2-р давхрын вистибюлыг заагласан эвхэгддэг шилэн хана хийх. Барилга байгууламжийн буулгах үйл ажиллагааны дүрэм БД 20-101-11/Барилга байгууламжийн буулгах үйл ажиллагааны дүрэм/. Бүлгийн өрөө коридор, шатны талбайд хальтардаггүй хулдаас дэвсэнэ. Бүлгийн өрөөний ариун цэврийн өрөөний шал, ажилчдын ариун цэврийн өрөөний шал, халуун цехд хальтардаггүй гадаргуутай керамик шал хийнэ. Ажилчдын өрөө, эрхлэгчийн өрөө, угаалгын өрөө, цагаан хэрэглэл хадгалах өрөөнүүдэд паркетан шал хийнэ. Шалны ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 31-09-05/Шалны ажил/. Барилгын гална ханыг шинээр фасадны эмульсээр будаж хийнэ. Бүлгийн өрөөнд төмөр зам угсарч дүүжин тааз хийнэ. Халуун цехд лампир тааз

хийнэ, бусад өрөөнд замаскан тэгшилгээ хийж ус чийгэнд тэсвэртэй сайн чанарын эмульсээр эмумьсдэнэ. Дотор, Гадна заслын ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 31-10-05/Заслын ажил/. Бүлгийн өрөө, коридор, ажилчдын өрөөний цонх хаалгын сольж бүлгийн өрөөнд аваарын давхар хаалга хийх. Хаалга цонхны ажлыг хийж гүйцэтгэхдээ MNS 5874-2008, MNS 5830-2007/Барилгын хуванцар (PVC) цонх, хаалганы техникийн шаардлага/. Дээврийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 31-07-05/Дээврийн ажил/ норм дүрмийг мөрдлөг болгон ажиллана. Тус ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахиун заавар заварчилгааг чанд сахин мөрдөн ажиллах.

## 2. Дотор гэрэлтүүлэгийн ажил

Барилгын розетка хүчит төхөөрөмж болон бусад цахилгаан хэрэгчлэгчдийн одоо байгаа чигээр нь ашиглана. Шинээр төлөвлөж буй гэрэлтүүлгийн зэм голтой ПВ утсыг ПНД хуванцар хар хоолойд сүвлэн хана болон таазаар сувагт шаардлаган дор далд татаж тэжээнэ. Дотор гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БД43-101-03 /Цахилгаан байгууламжийн дүрэм/, БНБД 3.05.0.6-90/Цахилгаан техникийн ажлыг мөрдлөг болгон ажиллана. MNS 6767:2019 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаарлагыг мөрдлөг болгон ажиллах.

### Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:**

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:**

САЙНШАНД СУМЫН  
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Б.ЭНХМАНЛАЙ